

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АЙМГУУДЫН ЗДТГ

2017 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД


2017 оны 4 дүгээр сард Өвөрхангай, Орхон, Дорнод, Говьсүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий, Архангай аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ууд 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь ил тод болгожээ. Шилэн дансны тухай хуулийн дагуу ил тод болгох ёстой мэдээллүүдээс зургаан төрлийн мэдээллийг сонгон авч 21 аймгийн ЗДТГ-ууд хэрхэн ил тод мэдээлж байгаад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд тогтмол ажиглалт хийж байна.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



2017 оны 4-р сард өмнөх сартай харьцуулахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь нийтэлсэн аймгийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу аймгуудын ЗДТГ-ын 2017 оны 4 дүгээр сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).



АЙМГУУДЫН ЗДТГ-ЫН НИЙТЭЛСЭН ГҮЙЛГЭЭ БА ТҮҮНД ХАМААРАХ ШИЙДВЭРҮҮД



(Тайлбар 1-ийг үзнэ үү)

ХУДАЛДАН АВАЛТ БА ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2017 оны 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Баян-Өлгий, Увс аймгуудаас бусад аймгийн ЗДТГ хуулийн хугацаанд нь буюу 5 дугаар сарын 8-ны дотор ил тод болгожээ.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 8 аймаг (Дархан-Уул, Дорноговь, Орхон, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Өвөрхангай)-ын ЗДТГ нийтэлжээ. Мэдээлэл нийтлээгүй зарим ЗДТГ "тухайн сард 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт хийгдээгүй" гэсэн тайлбар өгчээ.
- Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн таван аймгийн ЗДТГ хугацаанд нь нийтэлсэн. Харин 2, 3 дугаар саруудад 3 аймгийн ЗДТГ хугацаа хоцорч нийтэлсэн бол 4 дүгээр сарын байдлаар бусад аймгийн ЗДТГ уг төлөвлөгөөг ил тод болгоогүй хэвээр байна.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний тоог гаргахдаа шилэн дансанд ЗДТГ-ын тухайн сард нийтэлсэн нийт гүйлгээний тоог тоолж гаргасан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн тухайн сард хамаарах цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг болон худалдан авалтыг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас
- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторингийн дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.